## "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
## НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ГУРАВДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ

2019 оны 09 дүгээр сарын 10 — Багануур дүүрэг

| № | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцах байгууллага | Шалгуур үзүүлэлт | 2019 онд хүрэх түвшин, үр дүн | Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төг/, хөрөнгийн эх үүсвэр | Хэрэгжил-тийн хувь | Үнэлгээ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ** | | | | | | | | |
| **1.1. ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙГ ЦОГЦООР НЬ ХӨГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| 1-5 | 1.1.1.4. Багануур дүүрэгт "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах ажлыг эхлүүлнэ. | "Багануур үйлдвэрлэл, технологийн парк"-ийн дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ. | НҮИГ, БҮТП ОНӨТҮГ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 30 | Төр хувийн хэвшлийн түншлэл | 10 | |
| | | 1. 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг БХБЯ-ЗҮ-2017/011 дугаартай зөвлөх үйлчилгээний 2018/10 гэрээний дагуу Барилга хот байгуулалтын яамны захиалгаар "Мон Энержи Консалт" ХХК гүйцэтгэж эхэлсэн.<br><br>Паркийн Ерөнхий төлөвлөгөөг 2019.08.02-нд НИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.<br><br>2019.09 дүгээр сарын байдлаар Паркийн инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгаан хангамжаас | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бусад бүх тооцоо судалгаа, зураглалын ажилбар 100% дууссан.<br><br>Уг захиалгат ажлын гэрээний хугацааг 2019.06.28-ны өдрийн 2019/120 дугаартай нэмэлт, өөрчлөлт, сунгалтын нөхцөлөөр 2019.07.30-ны өдөр хүртэл сунгасан ч Мон-Энержи Консалт ХХК нь дараах үндсэн шалтгаануудаар дуусгаагүй байна.<br><br>- Эрчим Хүчний сайдын цахилгаан, дулааны техникийн нөхцөл олголтыг 2018.09.15 - 2019.03.01-ний өдрийг хүртэл түр зогсоох 134 дүгээр тушаал гарсан.<br>- Паркийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2013 онд тухайн үеийн Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яам нь ЭХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй тул техникийн нөхцөл олгох боломжгүйг мэдэгдсэн.<br><br>- БХБЯ-ны хүсэлтээр Паркийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг ХХААХҮЯ-ны архиваас гаргуулж ЭХЯ-ны Шинжлэх ухаан техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.<br>- Паркийн ТЭЗҮ-д тооцсон эрчим хүчний хэрэглээ нь Багануур дүүргийн цахилгаан хангамжийн хүчин чадлын нөөцөөс хангах боломжгүй байгаа тул паркийн төслүүдийг хэрэгжүүлэх үе шатанд хэсэгчлэн эрчим хүчний хэрэглээг тооцож холбохоор ЭХЯ-ны Эрчим хүч хангамжийн газартай зөвшилцөж байна.<br><br>Паркийн зүгээс зураг төслийн ажлыг ондоо багтаан дуусгахын тулд бүх талын бололцоот арга хэмжээг авч байна.<br><br>2. Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | батлагдсан МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 108,7 тэрбум төгрөгийг Паркийн ТЭЗҮ-д тусгагдсан тооцоог үндэслэн оруулж батлуулсан.<br>Уг хөтөлбөрт 2019 оны 02 сард хийсэн тодотголын саналыг УУХҮЯ-ны ХҮГТГ, нийслэлийн ХБТГ-т хүргүүлж улмаар Үндэсний хөгжлийн газарт дээрх санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уламжлав.<br><br>Монгол Улсын Их Хурлын 2019 оны 33 дугаар захирамжаар батлагдсан "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн 4.4.4.5-д "Багануур үйлдвэрлэл, технологийн паркийг ашиглалтад оруулах" гэсэн заалтыг үндэслэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын дунд хугацааны санхүүгийн тооцоог боловсруулж 265.81 тэрбум төгрөгийн /ерөнхий төлөвлөгөөний томсгосон тооцоогоор/ хөрөнгө оруулалтыг 2020-2025 онд хэсэгчлэн тусгах саналаа хүргүүлсэн.<br><br>Үүний үр дүнд улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар паркийн дэд бүтцийг бүтээн байгуулахад 2020 онд шаардлагатай 59,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийн тооцоог ЭХЯ, БХБЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ болон нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тус тус хүргүүлсэн. Үүнд:<br>• Цахилгаан хангамжийн агаарын шугам 110х35 2х25000 кВт дэд станц<br>• Хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтэц<br>• Хөнгөн үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтэц<br><br>Мөн БХБЯ нь улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтад паркийн 2020 оны хөрөнгө оруулалтын саналыг тусгаж Сангийн яаманд хүргүүлээд байна. | | | | |

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.МИЧИД-ЭРДЭНЭ